



**ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2017 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/113

Улаанбаатар хот

**Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа,
эрүүл ахуйн дүрэм батлах
тухай**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, "Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар" ТӨҮГ-ын дүрмийн 5.5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ДБҮЭГ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрмийг нэгдүгээр, ажлын хувцасны хангалт, нормыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг нийт албан хаагчдад, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтсийн дарга /Л.Эрдэнэбаатар/, Үйлчилгээ, ашиглалтын хэлтсийн дарга /А.Сүхбалт/ нарт тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ



Ё.НЯМЖАВ



ДБҮЭГ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар /цаашид "ДБҮЭГ" гэх/ -т хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангаж ажиллах, ажилтны эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. ДБҮЭГ-т хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангахад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль энэ дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

1.3. ДБҮЭГ-ын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-ийг Захирлын тушаалаар байгуулна.

1.4. ДБҮЭГ-н хэлтэс, нэгжүүдийн ажлын байр нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чанар, стандартыг бүрэн хангасан байх бөгөөд энэ ажиллагаанд хэлтэс, албаны дарга, хяналтын инженер, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэргэжилтэн, эрүүл ахуйч нар тус тус хяналт тавьж ажиллана.

1.5. Энэхүү дүрмийг ДБҮЭГ-ын нийт ажилтнууд дагаж мөрдөнө.

ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН ЭРХ ҮҮРЭГ

2.1. ХААЭА-н асуудал хариуцсан орон тооны бус зөвлөлийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэргэжилтэн, эрүүл ахуйч болон хэлтэс, албаны ажилтнуудыг оролцуулж 7-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр Захирлын тушаалаар байгуулна.

2.2. Зөвлөл нь дараах үүрэгтэй байна. Үүнд:

2.2.1. Газрын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, энэ талаар төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангах,

2.2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ түүний төсөв зардлыг газрын тухайн жилийн төсөвт тусгуулах, зарцуулалтад хяналт тавих,

2.2.3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлах, энэ чиглэлээр ажилтнуудад мэдлэг олгох сургалт зохион байгуулах,

2.2.4. Газрын ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулах ажлыг жил бүр тогтмол зохион байгуулах,

2.2.5. Ажлын байрны аюул, эрсдэлгүй байдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх саналыг удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх,

2.2.6. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэргэжилтэн, эрүүл ахуйч нарт ажил үүрэгт нь хамааралтай үүрэг даалгаврыг өгч биелэлтийг хангуулах,

2.2.7. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд тогтоосон журмын дагуу осол, хурц хордлогыг тогтоох, судлан бүртгэх, осол, хурц хордлогын шалтгааныг тогтоох акт, дүгнэлт гаргах,

2.3. Зөвлөл дараах эрхтэй. Үүнд:

2.3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг зөрчсөн ажилтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх саналыг гаргаж, шийдвэрлүүлэх,

2.3.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг хангах чиглэлээр үр бүтээлтэй ажиллаж байгаа алба, нэгж, албан хаагчийг шагнаж урамшуулах саналыг удирдлагад тавьж, шийдвэрлүүлэх.

2.3.3. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

ГУРАВ. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА

1. ДБҮЭГ-ын ажлын байранд:

3.1.1. Ажлын байр нь хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байна. Ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны норм, стандарт мөрдөгдөж байгаа эсэхэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны ажилтан хяналт тавьж, зохих стандарт алдагдсан тохиолдолд нэн даруй шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

3.1.2. Ажлын байр, ажилтны ажилд ирэх, буцах зам ,аюултай хэсэг болон аюул, осол гарч болзошгүй газруудад анхааруулах тэмдэг, зурагт хуудас болон машин тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны заавар санамжийг ил тод харагдах газарт ойлгомжтой бичиж тавина.

3.1.3. Ажилтан бүр нь галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал гарсан үед гал унтраах багаж хэрэгсэлтэй ажиллах, гал унтраах чадвар, мэдлэгийг эзэмшсэн байна . Ажлын байр болон ажлын орчин тойрны талбайд ил гал гаргах, амархан шатах материал, тэсэрч дэлбэрэх бодисыг ажлын байранд байлгахыг хориглоно.

3.1.4. Ажилтнууд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэдлэгээ байнга сайжруулж аюулгүй ажиллагааны дүрэм заавруудыг судлан мөрдөнө.

3.1.5. Ажлын байран дээрх осол, гамшигт нэрвэгсдэд анхны тусламжийг үзүүлэх арга барил, мэдлэгийг ажилтнууд эзэмшсэн байна. Мөн байгууллагын болон өөрийн ажиллаж байгаа хэсэг нэгж бүрийн "Гамшгийн үеийн ажлын төлөвлөгөө"-г судалж мэдсэн байх шаардлагатай.

3.1.6. Ажилчид нь өөрийн ажлын байр болон байгууллагын талбайд элдэв зүйл хаяж бохирдуулахгүй байх, ажлын байрны дэг журмыг хариуцаж ажиллана.

2. Зоог үйлчилгээнд:

3.2.1. Зоог үйлчилгээний ажилтан бүр ажил олгогчийн баталсан жагсаалтын дагуу ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдах ба тэдгээрийг зориулалтын дагуу бүрэн хэрэглэх үүрэгтэй.

3.2.2. Ажилтан нь өөрийн ажлын байрыг эзэнгүй орхихгүй байх, ажлын байранд гадны хүн оруулахгүй байх үүрэгтэй.

3.2.3. Ажил дуусахад шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээс бусад цахилгаан тоног төхөөрөмжийг тогноос салгаж, хөдөлмөр хамгаалалтын тусгай дэвтэр дээр тэмдэглэл хийнэ.

3.2.4. Гал тогоонд хэрэглэж байгаа тоног төхөөрөмж, хэрэгслийг зориулалт, норм стандарт, аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу ашиглана.

3.2.5 Гал гарсан тохиолдолд гарч буй газрыг илрүүлсэн ажилтан болон бусад хүмүүс гал унтраах бололцоотой арга хэмжээг авах ба байгууллагын шуурхай утсанд холбогдож, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэргэжилтэн болон холбогдох удирдлагуудад мэдээлэх үүрэгтэй.

3. Харуул хамгаалалтын алба

3.3.1. Харуул нь үүрэг гүйцэтгэх үедээ харуул хамгаалалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны болон галын аюулгүй байдлын дүрэм заавар, дэг журмыг чандлан сахиж ажиллана.

3.3.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны болон объектын аюулгүй байдалд нөлөөлж болох зөрчил дутагдлыг тухай бүрт харуулын алба, хариуцсан удирдлагад яаралтай мэдэгдэж холбогдох арга хэмжээ авхуулна.

3.3.3. Хамгаалж байгаа объектуудын хаалгыг онгойлгож хаахдаа цахилгаанд цохиулах, гэмтэх, дарагдахаас байнга сэргийлж, анхаарал болгоомжтой байна.

3.3.4. Ажилд гарахдаа хөдөлмөрийн нөхцөлд тохирсон хувцас, гутал, шаардлагатай бол бээлий, малгай өмсөнө.

3.3.5. Байгалийн үзэгдэл /бороо, цас, салхи, шуурга/-тэй үед ажил үүргээ гүйцэтгэхдээ орчны байдалд дүгнэлт өгч, нүх сувагт унах, ямар нэг зүйлд цохиулах, тээглэх, мөргөх зэрэг ослоос болгоомжилж ажиллана. Дээрх нөхцөлд ажиллахдаа гар чийдэн, бусад хэрэгслийг биедээ авч явна.

3.3.6. Ажлын байран дахь цахилгаан хэрэгсэлтэй зөв харьцаж, ажлын байрыг орхих үедээ шаардлагатай цахилгааны эх үүсвэрийг заавал салгана.

3.3.7. Гал түймэр, осол аваар гарсан нөхцөлд объектыг байнгын хяналтад байлгаж, мэдээг шуурхай дамжуулж, тусламж үзүүлэх гарц замыг чөлөөлөх арга хэмжээг авна. Гал гарсан тохиолдолд гал унтраах бололцоотой арга хэмжээг авч, байгууллагын шуурхай утас болон холбогдох удирдлагуудад мэдээлэх үүрэгтэй.

3.3.8. Ажилд гарах бэлтгэлээ дараах байдлаар хангана. Үүнд :

- 24 цаг үүрэг гүйцэтгэх хугацаанд хэрэглэх хоол хүнс бэлдэж ирсэн байх
- Унтаж амарсан байх

- Ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоог ханган ажиллах.
- Эмчилгээний эм бэлдмэл хэрэглэдэг бол зохих сав баглаа боодолтой авчирсан байх.

3.3.9. Хамгаалж байгаа объект, пост, хэсгийг орхиж явах, бусдад дур мэдэн шилжүүлэх, ажлын байранд гаднын хүн нэвтрүүлэхгүй байх.

3.3.10. Ажлын байранд согтууруулах ундаа болон мансууруулах төрлийн эм бэлдмэл /бодис/ хэрэглэхийг хатуу хориглоно.

4. Засвар үйлчилгээний алба

3.4.1. Ажилтан нь машин механизм, цахилгаан тоног төхөөрөмж, дулааны шугам сүлжээний гэмтэл, гал түймэр, болон үйлдвэрлэлийн осол, хор хөнөөл учруулж болзошгүй аюул илэрвэл хяналтын инженер болон шуурхай утсанд мэдэгдэж холбогдох албан тушаалтанд яаралтай мэдэгдэх үүрэгтэй.

3.4.2. Ажилтан нь аливаа тоног төхөөрөмж дээр ажиллахдаа аюулгүй байдлыг бүрэн хангаж, шаардлагатай тохиолдолд ахлах ажилтан болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэргэжилтнээс зааварчилгаа авч ажлыг эхлүүлж болно

3.4.3. Ажилтан нь мансууруулах төрлийн эм бэлдмэл /бодис/ болон согтууруулах ундаа хэрэглээгүй, ажил гүйцэтгэх бүрэн чадвартай байна.

3.4.4. Хувийн хамгаалах хэрэгсэл болон аюулгүй ажиллагааны төхөөрөмжүүдийг холбогдох дүрэм, зааврын дагуу ашиглана.

3.4.5. Ажлын хувцас болон хувийн хамгаалах хэрэгслийг ажилтан тогтмол хэрэглэж занших ба ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг тогтоосон хугацаанд шинэчлэн олгоно. Хортой нөхцөлд ажилладаг ажилчдад зохих журмын дагуу шаардлагатай хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүнээр хангана.

3.4.6. Ажилтан 1,5 м-ээс дээш өндөрт ажиллахдаа хамгаалах бүс хэрэглэх бөгөөд ажиллах талбай байхгүй газарт хашлагатай зориулалтын тавцан, шат ашиглана. Аливаа зүйлийг өргөх, буулгах мөн өндөрт ажил гүйцэтгэх үед багаж хэрэгсэл бусад зүйлс доош унаж болзошгүй аюултай бүсийг тогтоон харуул томилох бөгөөд шаардлагатай үед нэмэлт хаалт, хашлага, анхааруулах тэмдэг тавина.

3.4.7. Ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг зориулалт, норм стандарт, аюулгүй ажиллагааны зааварчилгын дагуу ашиглах,

3.4.8. Засвар үйлчилгээний албаны ажилтнуудад улиралд нэгээс доошгүй удаа аюулгүй ажиллагааны давтан зааварчилгааг, ажилд шинээр орж байгаа ажилтан бүрт аюулгүй ажиллагааны урьдчилсан зааварчилгааг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны ажилтан өгч баталгаажуулна.

3.4.9. Дэвшилтэд техник технологи, хөдөлмөрийн шинэ арга барил нэвтрүүлэх, аюулгүй ажиллагааны дүрэм заавар өөрчлөгдөх, түүнчлэн цахилгаан, дулаан хангамж, машин тоног төхөөрөмжийн бүтэц, эд анги, ажиллах зарчим өөрчлөгдөх тухай бүрд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ажилтан энэ талаар холбогдох бүх ажилтанд аюулгүй ажиллагааны ээлжит бус зааварчилгааг өгсөн байна.

3.4.10. Ажилчид нь зөвхөн өөрсдийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан буюу тухайн ажил хариуцсан удирдах албан хаагчийн зааварчилгын дагуу ажлыг гүйцэтгэнэ.

3.4.11. Ажилтан бүр ажил эхлэхийн өмнө ажлын байр, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, ажилд хэрэглэх багаж хэрэгсэл, дохиолол холбоо, гэрэлтүүлэг, хамгаалах хэрэгсэл, тоноглолын гэмтэлтэй эсэхийг шалган хэрэв зөрчил илэрвэл шуурхай арилгана. Боломжгүй бол энэ тухай холбогдох ажилтанд мэдэгдэнэ.

5. Автобааз:

3.5.1. Автобаазын жолооч нь ээлжинд гарахын өмнө эрүүл мэндийн шаардлага хангасан байна. Эрүүл мэндийн байдал муу, өвдсөн, даралт хэвийн бус /ихэссэн, багассан/, эрүүл мэндийн үзлэгээр тэнцээгүй жолоочийг ажилд гаргахыг хориглоно.

3.5.2. Автомашин бүрт галын хор, анхны тусламжийн эмийн сан, ослын гурвалжин тэмдэг, дугуйны зориулалтын эвүүр заавал байна.

3.5.3. Автобаазын хашаанд гадны хүн, машин техникийг оруулахыг хориглоно.

3.5.4. Тээврийн хэрэгслийг графикийн дагуу техникийн үйлчилгээ, оношилгоонд хугацаанд нь оруулж, үзлэг үйлчилгээг бүрэн чанартай хийлгүүлж, техникийн бэлэн байдлыг хангуулна.

3.5.5. Автобаазын дотор засвар үйлчилгээ хийх үед галын аюулаас сэргийлэх, холбогдох дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж, жолооч нарыг улиралд нэг удаа сургалтад хамруулж байна. Үүнд:

- Гамшгийн, анхны тусламжийн сургалт
- Галын аюулгүй байдлын сургалт
- Цахилгаан/сантехникийн сургалт

3.5.6. Авто машинуудын техникийн үзлэг оношилгоог тогтмол хийж, техникийн паспортыг байнга хөтөлнө.

3.5.7. Авто машиныг ажилд гарахын өмнө техникийн бэлэн байдал, бүхээгийн соёл, жолооч нарын хувийн ариун цэвэр зэргийг сайтар шалган гаргана.

3.5.8. Жолооч нарт автомашины засвар үйлчилгээ, замын хөдөлгөөний дүрмийн сургалтыг жил бүр тогтмол зохион байгуулж, шалгаж байна.

3.5.9. Ээлж солилцож байгаа жолооч нар машиндаа хамтран үзлэг шалгалт хийж техникийн бүрэн бүтэн байдлын талаар ээлж хүлээлцэх дэвтэрт тэмдэглэж гарын үсэг зурна. Жолооч өөрөө засаж чадахгүй эвдрэл, гэмтэл гарсан байвал механик ба диспетчерт мэдэгдэж эвдрэл гэмтлийг засуулсны дараа ажилд гарна. Бүрэн бус эвдрэл, гэмтэлтэй техниктэй ажилд гарахыг хориглоно.

3.5.10. Машины бүхээг дотор ажлын холбогдолгүй элдэв зүйл, шатах, тослох материал байлгахыг хориглоно.

Түр зогсох ба парклах үеийн аюулгүй ажиллагаа

- Ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоог ханган ажиллах.
- Эмчилгээний эм бэлдмэл хэрэглэдэг бол зохих сав баглаа боодолтой авчирсан байх.

3.3.9. Хамгаалж байгаа объект, пост, хэсгийг орхиж явах, бусдад дур мэдэн шилжүүлэх, ажлын байранд гаднын хүн нэвтрүүлэхгүй байх.

3.3.10. Ажлын байранд согтууруулах ундаа болон мансууруулах төрлийн эм бэлдмэл /бодис/ хэрэглэхийг хатуу хориглоно.

4. Засвар үйлчилгээний алба

3.4.1. Ажилтан нь машин механизм, цахилгаан тоног төхөөрөмж, дулааны шугам сүлжээний гэмтэл, гал түймэр, болон үйлдвэрлэлийн осол, хор хөнөөл учруулж болзошгүй аюул илэрвэл хяналтын инженер болон шуурхай утсанд мэдэгдэж холбогдох албан тушаалтанд яаралтай мэдэгдэх үүрэгтэй.

3.4.2. Ажилтан нь аливаа тоног төхөөрөмж дээр ажиллахдаа аюулгүй байдлыг бүрэн хангаж, шаардлагатай тохиолдолд ахлах ажилтан болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэргэжилтнээс зааварчилгаа авч ажлыг эхлүүлж болно

3.4.3. Ажилтан нь мансууруулах төрлийн эм бэлдмэл /бодис/ болон согтууруулах ундаа хэрэглээгүй, ажил гүйцэтгэх бүрэн чадвартай байна.

3.4.4. Хувийн хамгаалах хэрэгсэл болон аюулгүй ажиллагааны төхөөрөмжүүдийг холбогдох дүрэм, зааврын дагуу ашиглана.

3.4.5. Ажлын хувцас болон хувийн хамгаалах хэрэгслийг ажилтан тогтмол хэрэглэж занших ба ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг тогтоосон хугацаанд шинэчлэн олгоно. Хортой нөхцөлд ажилладаг ажилчдад зохих журмын дагуу шаардлагатай хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүнээр хангана.

3.4.6. Ажилтан 1,5 м-ээс дээш өндөрт ажиллахдаа хамгаалах бүс хэрэглэх бөгөөд ажиллах талбай байхгүй газарт хашлагатай зориулалтын тавцан, шат ашиглана. Аливаа зүйлийг өргөх, буулгах мөн өндөрт ажил гүйцэтгэх үед багаж хэрэгсэл бусад зүйлс доош унаж болзошгүй аюултай бүсийг тогтоон харуул томилох бөгөөд шаардлагатай үед нэмэлт хаалт, хашлага, анхааруулах тэмдэг тавина.

3.4.7. Ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг зориулалт, норм стандарт, аюулгүй ажиллагааны зааварчилгын дагуу ашиглах,

3.4.8. Засвар үйлчилгээний албаны ажилтнуудад улиралд нэгээс доошгүй удаа аюулгүй ажиллагааны давтан зааварчилгааг, ажилд шинээр орж байгаа ажилтан бүрт аюулгүй ажиллагааны урьдчилсан зааварчилгааг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны ажилтан өгч баталгаажуулна.

3.4.9. Дэвшилтэд техник технологи, хөдөлмөрийн шинэ арга барил нэвтрүүлэх, аюулгүй ажиллагааны дүрэм заавар өөрчлөгдөх, түүнчлэн цахилгаан, дулаан хангамж, машин тоног төхөөрөмжийн бүтэц, эд анги, ажиллах зарчим өөрчлөгдөх тухай бүрд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ажилтан энэ талаар холбогдох бүх ажилтанд аюулгүй ажиллагааны ээлжит бус зааварчилгааг өгсөн байна.

3.5.11. Машинаа удаан хугацаагаар парклахдаа жолооч нь тормосыг найдвартай бариулж, гэрлүүдийг унтрааж, моторыг хангалттай /5 мин/ хөргөсний дараа унтраана.

3.5.12. Цаг агаарын нөхцөлөөс шалтгаалж хөдөлгүүрийг асаалттай орхих шаардлагатай бол аваарын гэрлийг асаана.

3.5.13. Эвдэрсэн автомашиныг замын зорчих хэсэгт орхихыг хориглоно. Зөвхөн замын хөдөлгөөний дүрэмд заасан анхааруулах тэмдгийг хоёр талд нь /хойд, урд/ байрлуулан түр үлдээж болно.

3.5.14. Парклахдаа өөрийн сайн харагдах тал руугаа эргэх /нар буруу/ ба буруу тал руугаа /нар зөв/ эргэж болохгүй.

3.5.15. Ээлж хооронд тогтоосон талбайд машинуудыг эмх журамтай байрлуулна.

ДӨРӨВ. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА

1. ДБУЭГ-ын ажлын байранд:

4.1.1. Ажлын байранд ажилтнууд цэвэр, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажлын байранд өдөр тутам цэвэрлэгээг хийж, сард нэг удаа их цэвэрлэгээг хийнэ.

4.1.2. Ажлын байр нь ажиллах нөхцөлөөр хангагдсан, дулаахан, эрүүл ахуйн бүхий л нөхцөлийг хангасан байна.

4.1.3. Эмнэлгийн анхны тусламжийн хайрцгийг ажлын байранд байрлуулах ба шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлж бүртгэл хөтөлж нөхөн хангах.

2. Зоог үйлчилгээнд:

4.2.1. Зоог үйлчилгээний ажилтнууд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хагас жилд нэг удаа хамрагдах ба эрүүл мэндийн дэвтэртэй байна. Үүнд: - Хоолойн арчдас, - Цагаан хорхой, - Арьс өнгө

4.2.2. Гал тогооны шал, хана, хаалгыг өдөр бүр цэвэрлэж ариутгах ба их цэвэрлэгээг долоо хоног бүр хийнэ. Ажлын байрны өдөр тутмын угаалга, цэвэрлэгээг хийж бүртгэл хөтлөх бөгөөд цэвэрлэгээний багаж хэрэгсэл цэвэрхэн, цэвэрлэгээний дараа угааж халдваргүйжүүлсэн байна. Хүнсний зориулалтын угаалга цэвэрлэгээний бодис хэрэглэнэ.

4.2.3 Хоол хүнстэй харьцдаг ажилчдын ариун цэврийн өрөө, бохир усны цооног, хогийн савыг 7 хоногт 2 удаа 5-10%-ийн хлорийн шохойн уусмал болон ариутгалын бодисоор халдваргүйжүүлнэ.

4.2.4. Гал тогоонд шавьж устгал, мэрэгчийн устгал, халдваргүйжүүлэлтийг эрх бүхий байгууллагаар хагас жилд нэг удаа хийлгэн бүртгэл хөтөлнө.

4.2.5. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэж буй усыг “Ундны ус” MNS 900:2005 стандартын дагуу хагас жилд нэг удаа шинжилгээнд хамруулна.

4.2.6. Зоог үйлчилгээний ажилчид нь хувцасны өрөөтэй, ариун цэврийн өрөөтэй, гар угаах цэг нь халуун хүйтэн устай, саван ариутгалын бодис хүрэлцээтэй, гар хатаагч эсвэл цаасан салфеткатай байна. Ажиллагсад гараа бохирдох, ариун цэврийн өрөөнд орсон тохиолдол бүрт угааж халдваргүйтгэх ба энэ тухай санамж, зааврыг ажлын байранд байрлуулсан байна.

4.2.7. Зоог үйлчилгээний ажилчид албан үүргээ гүйцэтгэхдээ ил шархгүй, идээт үрэвсэлгүй, халдварт өвчнөөр өвчилсөн шинж тэмдэггүй, эрүүл байна. Ажилчдын эрүүл мэндийн байдлын талаар өдөр тутамд бүртгэл хөтөлнө.

4.2.8. Зоогийн үйлчилгээний ажилчид ажлын байранд ээмэг, бөгж, зүүлт, бугуйн цаг, гар утас хэрэглэхгүй ба гарын хумсаа ургуулж, будаагүй гарын ариун цэвэр сахиж ажиллана.

4.2.9. Зоогийн үйлчилгээний ажилчид нь хөдөлмөр хамгааллын /халад, хормогч, гутал, бээлий, үсийг бүрэн халхлахуйц малгай/ хувцсаар бүрэн хангагдсан байх ба ажлын хувцас нь цэвэрхэн 2 ээлжийн өнгө алдаагүй байна. Ажлын хувцасны угаалгын тусгай цэгтэй байна.

4.2.10. Зоог үйлчилгээний ажилчид хоол хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн Монгол Улс болон олон улсад дагаж мөрддөг үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/, эрүүл ахуйн зохистой дадал /GHP/-ын талаарх мэдлэгийг ажилтанд олгох сургалтад заавал хамрагдана.

4.2.11. Болсон болон түүхий мах, ногоо, загас далайн гаралтай бүтээгдэхүүн тус бүрт өнгөөр ялгаж тэмдэглэгээ тавих ба зориулалтын вандан тавиур, гамбанз тогоочийн багаж хэрэгсэл хэрэглүүлж тогтмол цэвэрлүүлнэ.

4.2.12. Нэг удаа бэлтгэсэн хоол, хүнснээс 150гр-аас багагүй хэмжээгээр дээж авч +4-өөс +8 хэмд 48-72 цаг хадгалах ба бүртгэлийг тогтмол хөтөлнө.

4.2.13. Түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн хадгалах хөргөх төхөөрөмжийн температурыг хянаж бүртгэл хөтлөх бөгөөд бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн, түүхий эдийг тус тусад нь зориулалтын саванд зориулалтын хөргөх төхөөрөмжид хадгалах ба хөргөх төхөөрөмж цэвэрхэн байна. Мал амьтан ургамлын гаралтай бүтээгдэхүүнүүдийг тус тусад нь хаяглаж, цэвэрхэн нөхцөлд хадгална.

4.2.14. Гаднын хүн хоол бэлтгэх, боловсруулах байр луу нэвтрэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд зориулалтын нөмрөг, малгай өмсгөж нэвтрүүлнэ.

4.2.15. Ялзарч муудсан, шимэгч амьтад, нян буюу хор, гаднын биет болон химийн хорт бодисоор бохирдсон, боловсруулах, бэлтгэх, дахин ялгах зэрэг үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааны явцад зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах боломжгүй түүхий эд болон орц, материалыг хүлээж авахыг хориглоно. Түүхий эд, орц материалыг дулаанаар боловсруулахын өмнө зайлшгүй ялгаж ангилан, сайтар шалгах бөгөөд шаардлагатай гэж үзвэл лабораторийн шинжилгээ хийнэ. Хоол үйлдвэрлэлд зөвхөн эрүүл ахуй, чанарын баталгаатай, эрүүл, стандарт шаардлага хангасан түүхий эд, орц материалыг ашиглана. Түүхий эд материалыг зохих стандартын дагуу хадгална.

4.2.16. Эмнэлгийн анхны тусламжийн хайрцгийг ажлын байранд байрлуулах ба шаардлагатай тохиолдолд анхан шатны тусламжийг мэдээлэл ирсний дагуу түргэн шуурхай очиж үзүүлэх ба бүртгэл хөтөлж нөхөн хангах.

4.2.17. Зоог үйлчилгээний эрүүл ахуйн нөхцөлийг эрүүл ахуйч өдөр тутамд шалгаж, бүртгэл хөтөлнө.

2. Зочид буудалд:

4.3.1. Зочид буудлын өрөө нь шүршүүр, ариун цэврийн өрөөтэй байх ба агааржуулалт сайтай, халтиралтаас хамгаалах резин байрлуулсан байна.

4.3.2. Зочинд олгох нэг удаагийн ариун цэвэр гоо сайхны бүтээгдэхүүн нь баталгаажилт хийгдсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан байна. Нэг удаагийн улавч хэрэглэх, нэг оронд цагаан хэрэглэл 3-аас цөөнгүй байх, цэвэрлэгээ үйлчилгээ халдваргүйтгэлийн бодисыг зөв тогтмол хэрэглэж хэвшсэн байна. Эрүүл ахуйч зочид буудлын эрүүл ахуйн байдлыг 7 хоног тутамд шалган бүртгэл хөтөлнө.

4.3.3. Зочид буудлын орчны талбай, барилга байгууламжийн засвар, үйлчилгээ, цэвэрлэгээ, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны үзлэг, хог хаягдал зайлуулах, хортон шавьжийн устгал, ариутгал, халдваргүйжүүлэлтийг эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын холбогдох стандартын дагуу хийсэн байна.

4.3.4. Эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнс, ахуйн зориулалтын түүхий эд, бүтээгдэхүүнээр хангагдсан байна.

4.3.5. Үйлчилгээний ажилтны биеэ авч явах байдал, харилцааны соёл, ёс зүй, гадаад үзэмж, хувцаслалт, нүүр будалт, инээмсэглэл, зочинтой харьцах, мэндчилгээ, ажлын байрны эмх цэгц зэрэг нь тухайн үйлчилгээний стандартыг бүрэн хангасан байна. Энгэрийн тэмдэг болон дүрэмт хувцастай байна.

4.3.6. Эмнэлгийн анхны тусламжийн хайрцгийг ажлын байранд байрлуулах ба шаардлагатай тохиолдолд эрүүл ахуйч анхан шатны тусламжийг мэдээлэл ирсний дагуу түргэн шуурхай очиж үзүүлэх ба бүртгэл хөтөлж нөхөн хангах.

4. Автобааз:

4.4.1. Жолооч нарын болон зочинд явах жолооч нарын хувийн ариун цэвэр, албан хувцаслалт, эрүүл мэнд зэргийг үзэж шаардлага хангаж буй жолооч нарыг ажилд гаргана.

4.4.2. Нийт автомашин болон зочинд гарах машины цэвэрлэгээ үйлчилгээг шалгаж цэвэрхэн машиныг зочинд гаргана.

4.4.3. Автобаазын ажлын байрны цэвэрлэгээнд хяналт тавьж, ажиллах цэвэр орчинг бүрдүүлэх.

4.4.4. Эмнэлгийн анхны тусламжийн хайрцгийг ажлын байранд байрлуулах ба шаардлагатай тохиолдолд анхан шатны тусламжийг эрүүл ахуйч мэдээлэл ирсний дагуу түргэн шуурхай очиж үзүүлэх ба бүртгэл хөтөлж нөхөн хангах.

ТАВ. БУСАД

5.1. Энэхүү журмыг зөрчсөн буруутай ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Энэхүү журмын хэрэгжилтэд Дэд захирал, хэлтэс, албаны дарга, дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн хяналт тавьж ажиллана.

---oOo---



АЖЛЫН ХУВЦАСНЫ ХАНГАЛТ, НОРМ

Ажлын хувцас хэрэглэх ажилтан	Хувцасны хангалт	Ажлын хувцасны норм
Барилгын засалчин	Өмд+хүрэм+Комбинзон+жилет+гутал+ + бээлий+маск+нүдний шил	12 сар
Цахилгаанчин	Өмд+хүрэм+Комбинзон+жилет+гутал+ +тусгай бээлий+нүдний шил	12 сар
Сантехникийн слесарь	Өмд+хүрэм+Комбинзон+жилет+гутал+ маск	12 сар
Засварчин	Өмд+хүрэм+ Комбинзон+гутал	12 сар
Харуул	Хүрэм	12 сар
Тогооч, туслах ажилтан	Өмд+цамц+малгай+хормогч+амны хаалт+гутал+бээлий /халуунаас хамгаалах, 1 удаагийн бээлий/	12 сар
Визитийн үйлчлэгч	Цамц+өмд+жилет+юбка+алчуур +бээлий /резинэн/	12 сар
Үйлчлэгч	Өмд+цамц+бээлий /резинэн/	12 сар
Жолооч /хогийн машины/ туслах ажилтан	Өмд+хүрэм+Комбинзон+жилет+гутал+ + бээлий+маск	12 сар
Хяналтын инженер, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэргэжилтэн	Хүрэм+жилет+каска	24 сар

ДБҮЭГ-ын ажлын тусгай хувцас нь "Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага MNS 13688:2000" Монгол улсын стандартын шаардлагыг хангасан байна.